

# СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦААНЫ ЖИШЭЭН ДЭЭР

*Л.Бямбахан*<sup>1</sup>

**Abstract:** *Strategic partnership, a contemporary paradigm in the dynamic landscape of international relations, represents a novel and collaborative approach to addressing the multifaceted challenges that have emerged in the global arena. As nations navigate the complexities of an ever-evolving geopolitical landscape, strategic partnerships have become instrumental in fostering cooperation and mitigating the complexities that arise in the realm of international affairs.*

*Within the realm of scholarly exploration, the author explores the essence of strategic partnerships by delving into the Japanese literature on the subject matter. This scholarly pursuit aims to unravel the nuanced components that define and characterize strategic partnerships, drawing insights from Japan's extensive experience in navigating intricate diplomatic relations.*

*Furthermore, this article serves as an illuminating beacon on the strategic partnership between Mongolia and Japan, offering a comprehensive exploration of the political, economic, cultural and defense dimensions that underpin their collaborative efforts. The researcher's perspectives and insights are seamlessly woven into the narrative, providing a nuanced understanding of the intricacies inherent in the Mongolia-Japan strategic partnership.*

**Key words:** Strategic partnership, Mongolia-U.S. strategic partnership, cooperation

## *Оршил*

Хүйтэн дайн төгсгөл болж, ЗХУ задарснаар олон улсын харилцаанд ноёрхож байсан хоёр туйлт тогтолцоо үгүй болсон билээ. Уламжлалт их гүрнүүдийн өрсөлдөөний оронд, олон улсын харилцаанд даяаршил хүч түрэн орж ирснээр Вестфалийн хэмээх үндэстэн улсуудын систем ганхаж, олон улсын байгууллага, үндэстэн дамнасан корпорациуд зэрэг улс бус тоглогчид (non-state actor) олон улсын харилцаанд өөрийн гэсэн байр суурьтай болж ирэв.

---

<sup>1</sup> Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн докторант, судлаач

Реалист онолын үүднээс олон улсын харилцааг тодорхойлохдоо улс орнуудын “амьд үлдэх” (survival)-ийн төлөөх тэмцэлд хөтлөгдсөн анархи тогтолцоо хэмээн үздэг байсан нь өөрчлөгдөж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, Хүйтэн дайны дараа улс орнууд хоорондоо олон улсын байгууллага, интергацуудын хүрээнд хамтран ажиллах нь эрс нэмэгдэв. Хамтын ажиллагаагаар дамжуулан улс орнууд энх тайван, аюулгүй байдлыг тогтоох боломж нээгдсэн билээ. Харилцааны түүхэн уламжлал, эдийн засгийн сонирхол, нийтлэг үнэт зүйл гэх зэргийг харгалзан улс орнууд түншлэлийн олон хэлбэрээс сонгож хоёр талын харилцаа хөгжүүлэх болов.

Хүйтэн дайны дараа бий болсон олон улсын харилцаанд их гүрнүүдийн хоорондын системийн шинжтэй өрсөлдөөн, тэмцэл намжиж, холбоотны харилцаанд тулгуурлан аюулгүй байдлаа хангах шаардлага багассан. Ингэснээр улс орнууд түншлэл тогтоох замаар харилцах нь түгээмэл болов. Гэвч ОХУ-ын 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Украинд эхлүүлсэн “цэргийн тусгай ажиллагаа”-ны улмаас улс орнууд цэргийн эвсэл холбоонд нэгдэх, цэргийн хамтын ажиллагаа өрнүүлэх нь мэдэгдэхүйц нэмэгдэж, батлан хамгаалах зардлаа огцом өсгөж байгаа юм. Энэ нь “шинэ хүйтэн дайн” эхэлсний дохио болов.

Монгол Улсын тухайд, хоёр их гүрний дунд оршдог геополитикийн байршилтай учраас хүчинд тулгуурлах, эвсэл холбоонд нэгдсэн бодлого явуулах нь ухаалаг бус шийдэл юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн 10.1-д “Монгол Улсын олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” хэмээн заасан байдаг.

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох ОХУ, БНХАУ-ын аль алинтай нь “иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Энэ нь манай улсын тухайд бусад оронтой тогтоосон хамгийн дээд түншлэлийн хэлбэр болоод байна. Үүний дараагаар “гуравдагч хөрш”-ийн орнууд болох АНУ, БНЭУ, Япон, БНСУ-тай “стратегийн түншлэл” тогтоогоод байгаа нь “гуравдагч хөрш”-ийн орнуудтай тогтоосон хамгийн өндөр түвшний харилцааны хэлбэр болж байна. Түүнчлэн Турк, ХБНГУ-тай “иж бүрэн түншлэл”-ийн харилцааны хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлж, Австрали, Канад улстай “өргөн хүрээтэй түншлэл”-ийн харилцаа тогтоон харилцаж байгаа юм. Эдгээр дурдсан оронтой харилцааны түвшин

ахиулж, “стратегийн түншлэл”-д дэвшүүлэх асуудал яригдаж, тодорхой бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Түншлэл нь олон улсын харилцааны шинэ үзэл баримтлал болох талаар тодорхой судалгаанууд хийгдсэн боловч түншлэлийн хэлбэр тус бүрийн онцлог, ялгааг иж бүрнээр нь гаргаж ирээгүй, тус бүрд нь тавигдах шалгуурыг тодорхойлоогүй, гол төлөв стратегийн түншлэлд ач холбогдол өгсөн байдалтай байна. Энэ нь зөвхөн стратегийн түншлэлээр хязгаарлагдалгүй түншлэлийн бусад хэлбэрийг судлах, тэдгээрийн ялгааг тодруулах замаар түншлэлийн хэлбэр тус бүрийн шалгуурыг тогтоох, ангилах шаардлагатай байгааг харуулж байгаа юм. Түншлэлийн хэлбэр тус бүрд тавигдах шалгуурыг тодорхойлсноор түншээ оновчтой сонгох, улмаар тухайн түншлэлд тулгуурласан хоёр талын харилцааг үр дүнтэй хөгжүүлэх, талуудын хүлээлтийг урьдчилан мэдэх боломжтой болно хэмээн үзэж байна.

Түүнчлэн, стратегийн түншлэлийн үзэл баримтлалыг судалсан олон улсын судалгаа нь гол төлөв ОХУ, БНХАУ-ын хоорондын стратегийн түншлэл, эдгээр улсын бусад талтай байгуулсан стратегийн түншлэлийн харилцаа, Европын Холбооноос улс орон, олон улсын байгууллагатай байгуулсан стратегийн түншлэлд төвлөрсөн байгаа нь судлагдсан байдлын судалгаанаас харагдлаа. Гэтэл “Өрнөдийн” хэмээн нэрлэгддэг орнууд ялангуяа АНУ болон Япон, Энэтхэг зэрэг нь улс бусадтай ямар үндэслэлийн улмаас “стратегийн түншлэл” тогтоодог болох тухай судалгаа хомс байна. Ялангуяа, “гуравдагч хөрш”-ийн орнууд болох АНУ, Япон, Энэтхэг, БНСУ нь ямар үндэслэл, шаардлагад тулгуурлан бусад орнуудтай түншлэл байгуулдаг болох, тэрхүү үндэслэл нь Монгол Улстай тогтоосон стратегийн түншлэлд давтагдаж байгаа эсэхийг судлах шаардлага тавигдаж байна.

Толилуулан буй өгүүллийн эхний хэсэгт стратегийн түншлэлийн үзэл баримтлалыг авч үзсэн бөгөөд чингэхдээ сэдэвтэй холбогдуулан Японы эрдэмтэн, судлаачид энэхүү түншлэлийн хэлбэрийг хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаад анхаарал хандуулахыг зорьсон болно. Өгүүллийн дараагийн хэсэгт Монгол Улс, Японы стратегийн түншлэлийг кейс болгон авч, судлаачийн зүгээс зохих дүгнэлт, саналуудыг дэвшүүллээ.

## **Нэг. Япон улсын стратегийн түншлэлийн харилцаа**

Япон улс нь сүүлийн жилүүдэд стратегийн түншлэл байгуулахад анхаарч байна. Жишээлбэл, тус улс 2006 онд БНЭУ, Индонез улстай, 2007 онд Австрали улстай, 2009 онд Вьетнам, Филиппинтэй тус тус стратегийн түншлэл байгуулсан. Японы бусад улстай байгуулсан стратегийн түншлэлийн харилцааг АНУ-Японы холбоотны харилцаанаас салгаж авч үзэх боломжгүй юм. Японы судлаач Такаши Терадагийн үзснээр *“АНУ-ын холбоотны харилцаа нь аюулгүй байдал, батлан хамгаалах түншлэлийг байгуулах Австрали, Японы ашиг сонирхлыг өдөөж өгсөн байна”*<sup>2</sup>. Хэдийгээр АНУ-Японы холбоотны гэрээ нь зөвхөн хоёр талын шинжтэй боловч АНУ-ын Зүүн Азийн орнуудтай байгуулсан хоёр талын холбоотны харилцааны сүлжээ болох “Сан Францискогийн тогтолцоо”-г ашиглан Япон нь Австрали, БНСУ-тай харилцаагаа өргөжүүлэх боломжийг олгосон. Гэтэл Хүйтэн дайн дуусгавар болсноор АНУ-тай байгуулсан холбоотны харилцаандаа итгэх Японы итгэл буурсан. Нөгөө талаар, Вашингтоны бодлого Ойрх Дорнодод анхаарах болсон нь Япон улсад “хаягдсан мэт” мэдрэмжийг төрүүлэх болов.<sup>3</sup> БНХАУ-ын өсөн нэмэгдэж буй нөлөө хийгээд газар нутгийн маргаан даамжрах болсон, Умард Солонгосын “цөмийн зэвсгийн аюул” зэргээс үүдэн Япон улс түншүүдээ төрөлжүүлэх хэрэгтэй болсон. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлаа хангахын тулд Япон улс дан ганц АНУ-д найдаад зогсохгүй, бүс нутгийн бусад улстай түншлэх хэрэгтэй болов.

Японы “стратегийн түншлэл”-ийн харилцааны нэг онцлог нь АНУ-ын холбоотон/түншүүдтэй ийм төрлийн харилцаа тогтоохыг эрмэлздэгт оршино. Ингэснээр дээр дурдсанчлан, түншүүдээ төрөлжүүлэх, олон улстай ердийн харилцаанаас илүү өргөнд харилцах боломжтой болоод зогсохгүй АНУ-ын бий болсон “Сан Францискогийн тогтолцоо”-нд хамрагдах орнуудын хоорондын хамтын ажиллагаа гүнзгийрүүлэх, улмаар Японы аюулгүй байдал хангах гол тогтолцоо болох АНУ-ын холбоотны тогтолцоог бэхжүүлэх ач холбогдолтой юм.

---

<sup>2</sup>Takashi Terada, (2010) “Evolution of the Australian–Japan Security Partnership: Toward a Softer Triangle Alliance with the United States?”, Japan Program, IFRI Center for Asian Studies [https://www.ifri.org/sites/default/files/atoms/files/av35\\_terada\\_japan-australia-us\\_alliance\\_2010.pdf](https://www.ifri.org/sites/default/files/atoms/files/av35_terada_japan-australia-us_alliance_2010.pdf)

<sup>3</sup>Thomas S. Wilkins, “Japan’s alliance diversification: a comparative analysis of the Indian and Australian strategic partnerships” International Relations of the Asia-Pacific Volume 11 (2011) 115–155

Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай стратегийн түншлэл тогтоохыг эрмэлзэж буй Японы хувьд “стратегийн түншлэл нь бодлогын сонголтын хэрэгсэл”<sup>4</sup> болсон байна.

Олон улсын өнөөгийн хандлагаас харахад улс орнууд Хүйтэн дайны үеийн уламжлалт холбоотны харилцаанаас татгалзаж байна.<sup>5</sup> Японы аюулгүй байдлын бодлого нь энэ хандлагыг тусгаж, Ази-Номхон далайн бүс нутагт шинээр төлөвшиж буй аюулгүй байдлын дэг журмыг бий болгоход хувь нэмрээ оруулж байна.<sup>6</sup> Төлөвшиж буй бүс нутгийн аюулгүй байдлын дэг журмын хүрээнд шинээр цэргийн эвсэл холбоо байгуулах нь бусад улсад болгоомжлол, хардлага үүсгэж болзошгүй учраас өдөөн хатгасан бус аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага Япон улсад тулгарсан. Иймд “ээдрээтэй ярвигтай, даяаршиж буй дэлхий ертөнцөд стратегийн түншлэл нь хоёрдугаар зэрэглэлийн гүрнүүдийн аюулгүй бодлогын сонголт болсон” хэмээн судлаач Видаяа Надкарни үзжээ.<sup>7</sup>

Стратегийн түншлэл нь шинэ тутам, хувьсан өөрчлөгдөж байдаг төдийгүй гэрээ хэлэлцээрээр үүрэг хүлээх нь бага байдаг учраас улс орнууд “стратегийн түншлэл” байгуулахыг илүүтэй сонирхох болсон. Өөрөөр хэлбэл, энэхүү хамтын ажиллагааны давхацсан, сул интеграцлагдсан сүлжээ нь дипломат ажиллагааны хувьд хүчин чармайлт ихээхэн шаарддаг, албан ёсны холбоотны харилцаанаас илүү үр дүнтэй байдаг учраас улс орнуудын энэ төрлийн харилцааг тогтоох нь сонирхол нэмэгдсэн.<sup>8</sup> Японы тухайд энэ хандлагыг тусган, стратегийн түншлэл тогтооход анхаарах болсон.

Япон улсын бусад улстай тогтоосон “стратегийн түншлэл”-ийн харилцааны нийтлэг шинж нь эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэхэд төвлөрсөн байдаг. Судлаач Кристофер Хьюзийн томъёолсноор, Японы аюулгүй байдлын цогц бодлого нь цэргийн хүчийг бэхжүүлэхээс гадна эдийн засгийн хүч чадлыг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч, эдийн

---

<sup>4</sup>Vidaya Nadkarni, (2010) *Strategic Partnerships in Asia: Balancing without Alliances*. Abingdon: Routledge

<sup>5</sup>Nobuo Okawara, Peter J. Katzenstein (2008) “Japan and Asian-Pacific security: regionalization, entrenched bilateralism, and incipient multilateralism”, in P. Katzenstein (ed.), *Rethinking Japanese Security: Internal and External Dimensions*, pp. 104–132. Abingdon: Routledge

<sup>6</sup>Thomas S. Wilkins, “Japan’s alliance diversification: a comparative analysis of the Indian and Australian strategic partnerships” *International Relations of the Asia-Pacific* Volume 11 (2011) 115–155

<sup>7</sup>Vidaya Nadkarni, (2010) *Strategic Partnerships in Asia: Balancing without Alliances*, Abingdon: Routledge

<sup>8</sup>Richard J. Samuels, (2007) *Securing Japan: Tokyo’s Grand Strategy and the Future of East Asia*. Ithaca, NY: Cornell University Press

засгийг тогтворжуулах, улсыг засан тохинуулахад чиглэж байв.<sup>9</sup> Энэ нь Япон, Австралийн байгуулсан “стратегийн түншлэл”-ийн харилцаанд тусгалаа олсноос харагдана.

Япон нь стратегийн түншлэл байгуулсан улсуудтайгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (нэг төрлийн чөлөөт худалдааны хэлэлцээр)-ийг гол төлөв байгуулж байна. Тухайлбал, БНЭУ-тай 2011 онд “Иж бүрэн эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг байгуулсан. Энэ хэлэлцээрийг байгуулсны дараагаас хоёр талын харилцаа бусад салбарт өргөжин хөгжиж, олон төрлийн гэрээ хэлэлцээр байгуулагдаж байна. Тухайлбал, 2015 онд Батлан хамгаалах тоног төхөөрөмж, технологи дамжуулах хэлэлцээр, Цэргийн зориулалттай нууц мэдээллийг хамгаалах зорилгоор аюулгүй байдлын арга хэмжээ авах тухай хэлэлцээр байгуулсан бол Энхийн зорилгоор цөмийн эрчим хүчнийг ашиглах тухай хэлэлцээрийг байгуулсан нь хоёр улсын түншлэлийг бэхжүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн. Эдгээр гэрээ хэлэлцээрийн тусламжтайгаар, Япон, Энэтхэг нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлээд зогсохгүй Энэтхэг далайн тэнгисийн зам харилцааны аюулгүй байдлыг хангах, зэвсэгт хүчнээ шинэчлэхэд бие биендээ тусалж байна.<sup>10</sup>

1947 оноос хойш хүчин төгөлдөр хэрэгжиж буй Японы “энхийг эрхэмлэсэн” Үндсэн хуулиас шалтгаалан Японы дотоодод аюулгүй байдлын аливаа эвсэл холбоонд болгоомжтой ханддаг. Судлаачдын ажигласнаар, 1980-аад оны эхэн хүртэл холбоотны харилцааг тодорхойлоход “холбоотон” буюу “domei” гэх үгийг ашиглахаас татгалзсаар иржээ.<sup>11</sup> Австралитай “стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтооход Канберрагийн зүгээс “(холбоотны) гэрээ” гэх үгийг ашиглахыг санал болгоход Токио “тунхаглал” гэх үгийг илүүд үзсэн байх жишээтэй.

### **Хоёр. Монгол-Японы стратегийн түншлэлийн харилцаа**

Ерээд оны эхээр Монгол Улс бие даасан, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого явуулах болсноор түншлэлийн харилцааг улс орнуудтай эрчимтэй байгуулах болсон. 1994 оны Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, Монгол Улс гадаад

---

<sup>9</sup>Christopher W. Hughes (2004) “Japan’s Security Agenda: Military, Economic & Environmental Dimensions” Boulder, CO: Lynne Rienner

<sup>10</sup>Lakhvinder Singh, “India-Japan strategic partnership must include Korea: Indian strategic thinkers who are putting all their eggs in the Japanese basket and ignoring South Korea are making a strategic blunder” (Jan 9, 2020) <https://asiatimes.com/2020/01/india-japan-strategic-partnership-must-include-korea/>

<sup>11</sup>Andrew L. Oros, (2008) Normalizing Japan: Politics, Identity, and the Evolution of Security Practice. Stanford, CA: Stanford University Press

харилцаандаа олон түнштэй байх бодлого явуулах тухай, Монгол Улс хоёр хөрш оронтой харилцах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, тэнцвэртэй харилцах зарчим баримтлах тухай, нөлөө бүхий орнуудтай зөвлөлдөж байх, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг Монголд буй болгох бодлого явуулах тухай ерөнхийлөн заасан байдаг<sup>12</sup> бол үүнийг нарийвчлан 1994 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд, *“Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо ... олон тулгуурт бодлого явуулна”*<sup>13</sup> гэжээ.

Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 онд ОХУ-тай “Сайн хөршийн уламжлалт түншлэл”, 2009 онд “Стратегийн түншлэл”, 2019 онд “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл”, 2003 онд БНХАУ-тай “Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл”, 2011 онд “Стратегийн түншлэл”, 2014 онд “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцааны эрхзүйн үндсийг тавив.<sup>14</sup>

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн тогтоолоор батлагдсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улсын улс төрийн гадаад бодлогын нэг хэсэг нь *“АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх”*<sup>15</sup> тухай заасан. Монгол Улс уг бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байгаа билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өрнө, дорнын улс, холбоотой түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх тухай заасан байдаг. Монгол Улс Японтой 1997 онд “Иж бүрэн түншлэл”, 2010 онд “Стратегийн түншлэл”, 2022

---

<sup>12</sup>Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар сарын 30, Төрийн мэдээлэл, 9/1994, 781 дүгээр тал

<sup>13</sup>Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар сарын 30, Төрийн мэдээлэл, 9/1994, 805-806 дугаар тал

<sup>14</sup>Д.Уламбаяр “Монгол Улсын түншлэлийн бодлого”

<sup>15</sup>Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 оны 2 дугаар сар

онд “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл” байгуулсан. Япон нь манай улстай Тусгай стратегийн түншлэлийн харилцаа бүхий анхны улс болж байна.<sup>16</sup> Мөн “Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр: 2013-2017”-ийг 2013 оны 9 дүгээр сард батлан хэрэгжүүлж, 2017 оны 3 дугаар сард хоёр дахь үе шатны “Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр: 2017-2021”-ийг хэрэгжүүлж, Японы Гадаад хэргийн Хаяши Ёшимасагийн 2022 оны 5 дугаар сард хийсэн айлчлалаар хөтөлбөрийн үр дүнг хэлэлцэж дүгнэж, тусгагдсан заалтууд үндсэндээ хэрэгжсэн хэмээн үзжээ.<sup>17</sup>

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Япон Улсад төрийн айлчлал 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хийсэн. Энэхүү айлчлал үеэр талууд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны замын зураглал болж ирсэн Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн, Монгол, Японы “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийг байгуулахаар тохиролцсон билээ.<sup>18</sup> Ингэснээр, Япон нь “гуравдагч хөрш”-ийн орнуудаас Монгол Улстай хамгийн өндөр түвшинд харилцаж байгаа улс болсон юм.

Хамтарсан мэдэгдлүүдээс гадна хоёр улсын харилцаа Тусгай стратегийн түншлэлд дэвшихэд өмнө нь байгуулсан гэрээ, хэлэлцүүрүүд эрх зүйн үндэс болно. Япон улстай 1990 оноос хойших хугацаанд байгуулсан эрх зүйн баримт бичгүүдийг дурдвал:

1. БНМАУ, Япон улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр (1990.03.20)
2. Японы Сайн дурынхныг хүлээн авах хэлэлцээр (1990.03.19)
3. Агаарын харилцааны Засгийн газар хоорондын хэлэлцээр (1993.11.25)
4. Япон улсын Ахмад сайн дурынхныг хүлээн авах тухай Засгийн газар хоорондын протокол, 1999 он
5. Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих засгийн газар хоорондын хэлэлцээр (2001.02.15)

---

<sup>16</sup>Монцамэ “Монгол, Япон: Стратегийн түншлэлээс Тусгай стратегийн түншлэл рүү” (2022.12.02) <https://montsame.mn/mn/read/309172>

<sup>17</sup>ГХЯ “Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн тухай” (2022.05.01) <https://mfa.gov.mn/67879>

<sup>18</sup>ЕТГ “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Япон улсад айлчилж байна” (2022.11.29) <https://president.mn/25434/>



6. Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр (2003.12.05).

Монгол, Японы Засгийн газар гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын зөвлөлдөх уулзалтууд үргэлжлэн тогтмол зохион байгуулагдаж байна.

- Монгол Улс, Япон Улсын ГХЯ хоорондын Стратегийн II зөвлөлдөх уулзалт 2017 оны 2 дугаар сард Улаанбаатар хотноо, III уулзалт 2018 оны 4 дүгээр сард Токио хотноо тус тус болов.
- Монгол Улс, Япон Улсын гадаад харилцаа, аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын IV зөвлөлдөх уулзалт 2017 онд Улаанбаатар хотноо, 8 дугаар V зөвлөлдөх уулзалт 2019 оны 4 сард Токио хотноо болов.
- Монгол Улс, Япон Улсын Батлан хамгаалах яамд хоорондын V зөвлөлдөх уулзалт 2019 оны 4 дүгээр сард Токио хотноо болов.

Улс төрийн харилцааны тухайд, Монгол Улс стратегийн түншлэлийн харилцаатай, “туравдагч хөрш”-ийн орнуудтай өндөр, дээд түвшний харилцан айлчлалыг тогтмолжуулсан. Тухайлбал, 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Япон улсын Ерөнхий сайд нар Монгол Улсад зургаан удаа айлчилсны дотор сүүлийн гурван айлчлал (Ерөнхий сайд Ш.Абэ 2013, 2015, 2016 онд Монгол Улсад айлчилсан) нь стратегийн түншлэл тогтоосноос хойш хийгдсэн. Харин манай улсаас Ерөнхий сайд С.Батболд 2012 онд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 онд, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2015 онд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2016 онд, Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 онд<sup>19</sup>, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 онд<sup>20</sup> Япон улсад тус тус айлчлав.

1974 онд парламентын түвшинд харилцаа тогтоосноос хойш тогтмол харилцаж, төлөөлөгчид жил бүр шахам харилцан айлчилж байна. Японы парламентын Зөвлөхүүдийн танхимын дарга Ю.Осада 1992 онд, Төлөөлөгчдийн танхимын дэд дарга К.Ватанабэ 1997 онд, Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Оошима 2017 онд тус тус манай улсад айлчилсан. Монгол Улсын Их хурлын дарга Н.Багабанди 1994 онд, Р.Гончигдорж 1999 онд, С.Төмөр-

<sup>19</sup>Гадаад харилцааны яам “Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон улсад айлчилна” (2018.12.10) <https://mfa.gov.mn/49231>

<sup>20</sup>Өнөөдөр сонин “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Японд айлчилна” (2020.07.21) <https://unuudur.mn/?p=181237>

Очир 2002, Д.Лүндээжанцан 2008 онд, Д.Дэмбэрэл 2011 онд, З.Энхболд 2015 болон 2016 онд, М.Энхболд 2017 онд тус тус Япон Улсад айлчлав.<sup>21</sup> Эдгээр айлчлалаас үзэхэд өндөр, дээд түвшний айлчлалын давтамж нэмэгдсэн болох нь харагдаж байна. 2015 онд гэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар 3 сарын дотор Японд айлчилсан нь хоёр талын улс төрийн харилцаа нягтарсныг харуулсан билээ.

Монгол Улс ДХБ-ын 160 гаруй гишүүн оронтой аливаа бүс нутгийн болон хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдээгүй цорын ганц орон байсан билээ. Манай Улс Япон улстай анхны чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан явдал эдийн засгийн гадаад харилцааны салбарт сүүлийн 20 жилд гарсан том амжилт болов. 2015 оны 2 дугаар сард байгуулж, 2016 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр мөрдөх болсон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) буюу Economic Partnership Agreement нь Япон улсын хувьд 15 дахь чөлөөт худалдааны хэлэлцээр байсан юм.

Хоёр улсын хоорондын худалдаанд ЭЗТХ хэрхэн нөлөөлснийг гадаад худалдааны статистик мэдээлэл дээр дүн шинжилгээ хийж авч үзье. ЭЗТХ байгуулснаар хоёр орны 2012 оны худалдааны статистикаас харахад, гадаад худалдааны бараа эргэлт жилд 50-60 хувиар нэмэгдэх урьдчилсан тооцоо гарч байв. Хоёр талын худалдааны эргэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 601 сая ам.долларт хүрч, хэлэлцээр байгуулахаас өмнөх 2015 онтой харьцуулахад 2 дахин өссөн нь сүүлийн 15 жилийн хугацаанд байгаагүй өндөр үзүүлэлт болов (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

***Хүснэгт 1. Монгол, Японы бараа эргэлт (2016 онтой харьцуулсан байдал)***

Жилийн эцсийн байдлаар	Экспорт (мян ам.доллар)	Импорт (мян ам.доллар)	Нийт эргэлт (мян ам.доллар)	Экспортыг 2016 оны дүнтэй харьцуулсан байдал	Импортыг 2016 оны дүнтэй харьцуулсан байдал
<b>2016 он</b>	14,031	330,618	344,649	-	-
<b>2017 он</b>	14,816	363,150	377,966	5.6% өссөн	9.9% өссөн
<b>2018 он</b>	26,468	561,042	587,510	88.6% өссөн	69.7% өссөн
<b>2019 он</b>	15,517	585,478	600,995	10.5% өссөн	77.1% өссөн

<sup>21</sup>Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>

<b>2020 он</b>	9,628	406,712	416,340	31.4% буурсан	23.0% өссөн
----------------	-------	---------	---------	---------------	-------------

Эх сурвалж: ГЕГ-аас гаргасан гадаад худалдааны статистик мэдээлэл

Хүснэгт 1-ээс үзэхэд, Монгол-Японы ЭЗТХ 2016 онд хүчин төгөлдөр болсноос хойш буюу 2017 оноос эхлэн хоёр талын худалдаа нэмэгдсэн байна. ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс хойш хоёр орны худалдаа жил бүр өссөн бөгөөд 2018 онд огцом өсч, 2016 онтой харьцуулахад экспортын хэмжээ 88.6 хувиар, импортын хэмжээ 69.7 хувиар, худалдааны нийт эргэлт 242.87 сая ам.доллараар өсч, 580 сая ам.долларт хүрсэн байна.

Манай улсаас Япон руу гаргах экспорт 2018 онд 26.5 сая ам.доллар байсан бол 2019 онд экспорт 41 хувиар буурчээ. 2020 онд ковид-19 цар тахлын улмаас олон улсын тээвэр, логистикийн үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор экспортын хэмжээ 2016 оны түвшнээс 31.4 хувиар буурсан байна.

Монгол Улс, Япон хоорондын худалдааны нийт бараа эргэлт 2021 онд 470.9 сая ам.доллар болж, 2016 оноос 126.3 сая ам.доллар буюу 27.0 хувиар өссөн бөгөөд экспорт 17.7 сая ам.доллар, импорт 453.1 сая ам.доллар байна. Монгол Улсын гадаад худалдаанд Япон улсын эзлэх хувь 2016 онд 4.17 хувийг эзэлж байсан бол 2021 онд 2.93 хувийг эзэлж байна.

Монгол Улсаас Япон руу экспортлосон бараа, бүтээгдэхүүний ихэнх буюу 40-55 хувийг нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл буюу ноос, ноолууран бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд ковид-19 цар тахлын улмаас 2019-2020 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт үндсэндээ зогссон. Манай импортын барааны бүтцэд ковид-19 цар тахлын үед буюу 2019-2020 онд ч төдийлөн өөрчлөлт ороогүй бөгөөд нийт импортын 70 орчим хувийг автомашин эзэлж байгаа бол тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл 14 хувийг эзэлж байна.

2016 оныг хүртэл Япон улсаас манай улсад нийт 262 сая долларын хөрөнгө оруулалт хийгдэж, түүний ихэнх боловсрол, нийгмийн салбарт ногджээ. 2015 оны байдлаар Японы 551 компани Монгол Улсад бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байжээ.<sup>22</sup> Хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 онд хамгийн их буюу 8.9 сая ам.доллар хүрсэн нь ЭЗТХ-ийн үр нөлөө гэж дүгнэж болохоор байна. 2019-2021 онд буурсан нь ковид-19 цар тахлын улмаас

<sup>22</sup>Б.Сэржав “Монгол, Японы дипломат харилцаа: гүнзгийрэл, чиг хандлага” Олон улс судлал №1 (107), 2017 он: 5-23 тал

эдийн засгийн харилцаанд хүндрэл үүсч, хөрөнгө оруулалтын орчин муудсантай холбоотой гэж үзэж болно.

2020 оны байдлаар Японы хөрөнгө оруулалттай нийт 670 компани Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байв. ЭЗТХ хэрэгжиж эхэлснээс буюу 2016 оноос хойш 100 орчим компани Монгол Улсад хөрөнгө оруулсан бөгөөд Японы манай улс дахь хөрөнгө оруулалт уул уурхайн бус салбарт төвлөрч байгаа нь хөрөнгө оруулалтыг солонгоруулахад чиглэсэн манай улсын бодлого, хөтөлбөртэй нийцэж байгаа нь сайшаалтай юм. Нийт хөрөнгө оруулалтын 45.3 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт, 14.7 хувь нь барилгын салбарт чиглэсэн байна.

ЗХУ болон Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл задарснаар Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн. Шилжилтийн эхний жилүүдэд эдийн засгийн бүхий л салбар зогсонги байдалд орсон. Энэ үед Япон зэрэг “Гуравдагч хөрш”-ийн донор орон, банк, санхүүгийн байгууллагууд Монгол Улсад дэмжлэг үзүүлж, олон төрлийн зээл, тусламж олгосон байна. Үүнд юун түрүүнд Японы оруулж буй хувь нэмрийг онцгойлон дурдах шаардлагатай. Монгол Улсад үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээгээр авч үзвэл Япон нь манай улсын хамгийн том санхүүгийн түнш юм.

Япон улс нь Монголыг шилжилтийн хүнд хэцүү үеийг даван туулахад эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлээд зогсохгүй манай улсын олон улсын механизмд нэгдэн ороход улс төрийн дэмжлэг үзүүлсээр ирсэн. Эдгээрээс дурдвал:

- 1991 оноос Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагчдын уулзалтыг Токио хотноо 10 удаа зохион байгуулсан.
- Япон Улс “Их 7”-гийн дээд хэмжээний 1991, 1992, 1993 оны уулзалтуудын төгсгөлийн баримт бичгүүдэд Монголын ардчиллыг улс төр, эдийн засгийн талаар дэмжих тухай заалтуудыг оруулж байсан.
- Манай улсыг КОКОМ-ын хязгаарлалтаас чөлөөлөх, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн худалдааны байгууллагад элсэхэд дэмжсэн.
- Монгол Улс АСЕМ, АРФ, ПЕКК-ийн гишүүн болох, АПЕК-ийн 4 ажлын хэсэгт ажиглагчаар элсэхэд дэмжлэг үзүүлэв.
- Монгол Улс ERIA-д оролцоход, улмаар элсэхэд дэмжлэг үзүүлж байна.

Японы Засгийн газар нь Монгол Улстай дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэл олон салбарт эдийн засгийн тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд 2017 оны 3 дугаар сарын сүүлийн байдлаар нийт тусламжийн хэмжээ 326.7 тэрбум хүрээд байна (Хүснэгт 2-ыг үзнэ үү). Япон улсын эдийн засгийн тусламж, дэмжлэг нь Монгол Улс ардчилсан нийгэмд шилжих явцад тулгарсан эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй он жилүүдийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

**Хүснэгт 2. Япон улсын үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээ (1977-2021 он)**

Зээл тусламжийн төрөл	Хэмжээ (тэрбум иен)
Буцалтгүй тусламж	123.6
Хөнгөлттэй зээл	182.9
Техникийн хамтын ажиллагаа	58.4
<b>Нийт</b>	<b>364.9</b>

Эх сурвалж: ЭЗХЯ-ын Хөгжлийн судалгааны газар, 2022 он

Өнгөрсөн хугацаанд олон төсөл хэрэгжсний дотор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл”, “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл”, “Дулааны IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл” багтаж байна. Японы талаас сүүлийн жилүүдэд хийсэн томоохон хөрөнгө оруулалт бол Монгол-Японы хамтарсан эмнэлэг юм. Тус эмнэлгийг барихад Япон улсын Засгийн газраас нийт 9 тэрбум 378 сая иений хөрөнгө оруулалт, Монгол Улсын Засгийн газраас 57.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.<sup>23</sup>

Монгол Улс, Япон Улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэлээд идэвхжих хандлагатай байна. Энэ нь хоёр улсаас бүс нутагт явуулж буй дипломат бодлого, үйл ажиллагаатай нягт уялдаатай. Бүх түвшний харилцан айлчлал, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл солилцох, зөвлөлдөх уулзалт, цэргийн боловсон хүчний сургалт, цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр хамтран ажиллах зэрэг олон хэлбэрээр хамтын ажиллагаа явуулж байна. Ялангуяа хоёр орны батлан

<sup>23</sup>П.Оюунцэцэг “Эрүүл мэндийн салбар дахь Монгол-Японы хамтын ажиллагаа”, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл №3, 2022: 52-53 тал

хамгаалах хамтын ажиллагаанд цэргийн инженер, цэргийн эмнэлэг гэсэн үндсэн 2 чиглэлийг тодорхойлон амжилттай хэрэгжүүлж байна.<sup>24</sup>

2000 оны 4 дүгээр сард Япон улсын Засгийн газраас Монгол Улстай батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоохоор шийдвэрлэж тус улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Батлан хамгаалахын атташег Монгол Улсад хавсран суулгахаар болж, Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлээр Японтой батлан хамгаалах салбарт харилцаа тогтоохоор шийдвэрлэсэн.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2019 оны 12 дугаар сарын 1-4-ний өдрүүдэд Япон Улсад 5 жил хагасын дараа албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд хоёр улсын Батлан хамгаалахын сайд нар албан ёсны хэлэлцээ хийсэн бөгөөд Япон Улсын Батлан хамгаалахын сайд Т.Коно хүндэтгэлийн зоог барив. Мөн айлчлалын үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд Гадаад хэргийн сайд Т.Мотэги, Парламент дахь Төлөөлөгчдийн танхимийн Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяши нартай тус тус уулзав.

Батлан хамгаалахын сайд нарын албан ёсны хэлэлцээгээр талууд хоёр улсын батлан хамгаалах харилцаа шинэ агуулгаар баяжин өргөжиж, хоёр талдаа харилцан цэргийн атташе суулгаад буйг сайшаан тэмдэглэв. Түүнчлэн цаашид цэргийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, цэргийн инженер, түүний дотор цэргийн эмнэлгийн салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, Монголд техник, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулах зэрэг чиглэлд хамтран ажиллахаар тогтов. Японы тал өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын Зэвсэгт хүчин ЭСА-ны газар оронд өндөр түвшний ус зайлуулах байгууламж бүхий автозамыг барих чадвартай болсныг өндрөөр үнэлэв. Монголын тал “Гадаад харилцаа, Батлан хамгаалахын сайд нарын зөвлөлдөх уулзалт”-ын механизмыг цаашид хоёр талын харилцаанд нэвтрүүлж тогтмолжуулах нь ач холбогдолтой гэж үзэж буй гэсний хариуд

---

<sup>24</sup>VIP76 “Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ Японы Батлан хамгаалах яамны бодлогын газрын захирал Омасу Изаваг хүлээн авч уулзлаа” (2017 оны 8 дугаар сарын 29) <http://vip76.mn/content/47939>

японы тал уг асуудлаар ажил хэргийн түвшинд үргэлжлүүлэн санал солилцож ажиллахаа илэрхийлэв.

Албан ёсны айлчлалын үеэр Батлан хамгаалахын сайд Н.Энхболд дагалдан яваа төлөөлөгчдийн хамтаар Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургуульд зочлон, тус сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, уг сургуульд суралцаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 офицер, сонсогч нартай уулзав. Түүнчлэн Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний Эрүүл мэндийн сургууль, Өөрийгөө хамгаалах хүчний Төв эмнэлэгт тус тус зочилж, үйл ажиллагаатай нь танилцаж, хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Японы Өөрийгөө хамгаалах хүчний Хуурай замын цэргийн инженерийн сургалтын багтай хамтран “Зам” сургалтыг 2014 оноос 3 үе шаттай хэрэгжүүлж байна. 2017 оны 8 дугаар сарын 22-30 өдөр зохион байгуулсан “Зам-2017” сургалтын онцлог нь авто замын ус зайлуулах байгууламжийг барихад чиглэсэн. 2018 оны 7-8 дугаар сар, 2019 оны 4,5 дугаар сард, 2019 оны 8,9 дүгээр сард Монголын цэргийн инженерийн нэгжийн зам, барилгын салбар дахь хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалт хэрэгжүүлэв. Японы талтай ийнхүү хамтран ажилласнаар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх “Барилга, инженерийн рот”-ын бэлтгэлийг хангах боломжтой болж байна.<sup>25</sup>

Япон улс 2012 оноос эхлэн гадаадын улс орнуудын батлан хамгаалах салбарт тусламж үзүүлдэг болсон бөгөөд боловсрол, хүний нөөцийн чиглэлээр өөрсдийн туршлагыг хуваалцах, тусламжийг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж, Япон улсын Батлан хамгаалах яамнаас “Чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг гадаад улс орнуудад хэрэгжүүлж байна. “Монгол-Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-т тусгагдсан Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх хамтын ажиллагаа болон энэхүү хөтөлбөрийн хүрээнд манай улстай хамтран цэргийн эмнэлгийн чиглэлээр 2014-2016 онд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн.<sup>26</sup>

---

<sup>25</sup>Дэслэгч Д.Мөнхзориг, Соёмбо сонин “Япон улсын туршлагыг монголын хөрснөө ...” (2017.08.27) <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1489>

<sup>26</sup>Монгол Улсын Батлан хамгаалах яам “Монгол, Японы Засгийн газар хооронд энхийг сахиулах ажиллагаанд хамтран ажиллах гэрээ байгууллаа” (2015.06.0) <http://mod.gov.mn/index.php?com=news&id=700>

Хүмүүнлэгийн тусламж, үр дагаврыг арилгах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалтын хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Япон улсаас Монгол Улсад суугаа Бүрэн эрхт Элчин сайд Т.Шимизү нар 2015 оны 6 дугаар сарын 2-ны өдөр гарын үсэг зурав. Хэлэлцээрийн зорилго нь хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах боломжийг бий болгох, энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.<sup>27</sup>

Япон улсын Өөрийгөө хамгаалах хүчнээс манай улсад зохион байгуулдаг “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуульд ажиглагчаа байнга илгээн оролцуулж байна. Тухайлбал, Японы Хуурай замын Өөрийгөө хамгаалах хүчнээс 2017 оны 7-8 дугаар сар, 2018 оны 6 дугаар сард тус тус оролцож, 2019 оны 6 дугаар сард хамгийн өргөн буюу 60 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцов.<sup>28</sup>

Монгол Улсын цэргийн эмч нарыг онцгой байдлын үеэрх эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх сургалтад 2018 оны 2 дугаар сар, 2019 оны 3 дугаар сард хамруулав.

Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах академи, Батлан хамгаалах судалгааны хүрээлэн, Хуурай замын ӨХХ-ний команд штабын сургалтад 2018 онд 4 сонсогч суралцахаар ирсэн бол 2019 оны хичээлийн жилд 2 сонсогч, 3 офицер суралцахаар ирсэн. 2019 оны байдлаар Монгол Улсын Зэвсэгт хүчний 57 офицер Япон улсад суралцаад байна. Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг саадгүй хэрэгжүүлэхэд Японд суралцсан оюутнууд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Монгол Улс, Япон улстай оны Соёлын харилцааны хэлэлцээр байгуулж, 1976 онд анхны монгол оюутныг судлаач оюутнаар хүлээж авснаар Япон-Монголын оюутны солилцоо эхэлжээ. Дэлхий дахинд цар тахал дэгдэхээс өмнө буюу 2019 оны 12 дугаар сарын байдлаар 3124 монгол оюутан Япон улсад суралцаж байсан нь тус улсад суралцаж буй

---

<sup>27</sup>Мөн тэнд

<sup>28</sup>Монгол Улсаас Японы улсын Осака хот дахь Консулын газар “Монгол, Японы батлан хамгаалах салбарын харилцаа” <https://osaka.consul.mn/index1.php?moduls=13>



оюутны тоогоор бусад улс оронтой харьцуулахад 13 дугаар байрт орж байсан бөгөөд 10,000 хүн тутамд ногдож буй суралцагсдын тоогоор эхний байр эзэлж байсан байна.<sup>29</sup>

2007 оны 2 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Япон улсад хийсэн төрийн айлчлалынхаа үеэр Япон улсын Ерөнхий сайд Шинзо Абэгийн хамт Монгол, Японы Иж бүрэн түншлэлийн үндсэн хөтөлбөрт гарын үсэг зурсан бөгөөд иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээрт “боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ” хэмээн тунхагласан. Монгол, Японы харилцааны 50 жилийн түүхэн ойг тохиолдуулан 2022 оныг “Монгол, Японы хүүхэд, залуучуудын найрамдал, солилцооны жил”-ээр зарласан.

2013 оны байдлаар Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр манай 216 оюутан хууль, эдийн засаг, мэдээллийн технологи, анагаах ухаан, соёлын чиглэлээр суралцаж байна. Түүнээс гадна Японы Боловсролын яамны тэтгэлгээр жилд 70 орчим оюутан, “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” (JDS)-ийн тэтгэлгээр 18 оюутан, түүнчлэн, JICA-гийн богино хугацааны сургалтад 10-20 хүн хамрагдаж байна. 2019 оны байдлаар магистрын сургалтад 38, докторантурт 4 хүн тус тус суралцаж байна.<sup>30</sup> Мөн 2019 оны байдлаар Япон Улсад судалгаа хийж докторын зэрэг хамгаалсан, мөн докторын зэрэг горилон судалгаа хийж буй 200 гаруй оюутан байна.<sup>31</sup>

Түүнээс гадна Япон улсад 1005 инженерийг бэлтгэх зорилготой “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг Монгол Улс, Япон улсын засгийн газар 2014-2023 он хүртэл хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл нийт 75 сая долларын өртөгтэй бөгөөд механик, барилга, цахилгаан электроникийн хос хөтөлбөрт 320, магистрантурт 100, докторантурт 60, зэргийн бус сургалтад 325, мэргэжил олгох Коосэн сургалтад 200 гээд нийтдээ 1,005 хүн зам барилга, механик, нисэхийн инженер, үйлдвэрлэлийн инженер, цахилгаан электроникийн инженерээр суралцах юм. Гэхдээ уг хөтөлбөр нь буцалтгүй тусламж биш бөгөөд зээлийн гэрээний дагуу 75 сая долларыг Япон улсаас жилийн 0.2 хувийн хүүтэйгээр зээлж байгаа юм. Уг зээлийг 20 жилийн хугацаанд буцаан төлөх ёстой. Монгол Улсад 30,000 гаруй инженерийн хэрэгцээ бий гэсэн судалгааг Японы тал хийсэн байдаг. Энэ орон зайг

---

<sup>29</sup>Япон улсын ЭСЯ, Гадаад оюутны солилцоо <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/ryuugaku.htm>

<sup>30</sup>ГХЯ “Монголын докторууд Токиод чууллаа” (2017.05.08) <http://www.mfa.gov.mn/?p=40560>

<sup>31</sup>Мөн тэнд

нөхөхийн тулд энэхүү төслийн хүрээнд инженер технологийн чиглэлээр мэргэших сонирхолтой 40-50 оюутныг жил бүр Япон Улс руу илгээснээр 2023 он гэхэд 1,000 гаруй инженер бэлтгэхээр төлөвлөж байгаа юм.<sup>32</sup>

Хамгийн сүүлийн үеийн статистик мэдээллээр буюу 2019 оны байдлаар Монгол Улсад гурван “Косэн” загварын сургууль үйл ажиллагаа явуулж байна.

1. “Монгол Коосэн” Технологийн коллеж - нийт оюутны тоо 280
2. “Шинэ Монгол” Технологийн коллеж – нийт оюутны тоо 370
3. “ШУТИС-Коосэн” Технологийн коллеж – нийт оюутны тоо 166

Тус косэн сургуулиудад барилга, цахилгаан, механик, био-химийн инженерийн мэргэжлээр оюутнуудыг сургаж байна. “Косэн” загварын сургуулийг 2019 оны 6 дугаар сарын байдлаар нийт 141 оюутан төгссөн байна. Төгсөгчдийн 25 хувь нь японы компанид, 50 хувь нь монголын компаниудад ажилд орж, үлдсэн 25 хувь нь их дээд сургуульд дэвшин суралцаж байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд 2019 онд нийт 207 оюутан Японд суралцаж буйгаас үндсэн сургалтын хөтөлбөрт 81 хүн, хос хөтөлбөр (бакалаврын сургалт) 55, магистр 17, докторын сургалтын хөтөлбөрт 36, судлаач оюутан 3, зэргийн бус сургалтын хөтөлбөрт 17 хүн тус тус суралцаж байв.

МУИС болон Японы Токио, Осакагийн Гадаад хэлний дээд сургуулиуд хооронд 1975 оноос монгол, япон хэлний багш нарыг харилцан солилцож эхэлсэн. Манай их, дээд сургуулиуд 1975 оноос Япон улсаас оюутан элсүүлэн сургаж эхэлсэн бөгөөд одоо 7 япон оюутан монгол хэлний сургалтад хамрагдаж байна. Японы 10 гаруй их, дээд сургуульд монгол хэлний сургалт явуулж, монголын түүх, соёл, улс төр, эдийн засгийн судалгаа хийж байгаагийн зэрэгцээ эгнээндээ 300 гаруй судлаачдыг нэгтгэсэн “Монгол судлалын нийгэмлэг” үйл ажиллагаа явуулж байна. Мөн археологи, палеонтологи, угсаатны зүй, биохими зэрэг чиглэлээр эрдэмтдийн хамтарсан судалгаа хийгдэж, соёлын өвийг хамгаалах

---

<sup>32</sup>МУИС “Японд 1000 инженер бэлдэнэ” (2016-01-29) <http://news.num.edu.mn/?p=31949>

салбарт Монгол, Японы эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжин тэлж байна.<sup>33</sup>

Орон нутгийн шууд хамтын ажиллагааны хүрээнд 1990-ээд оноос Төв аймаг Тоттори мужтай, Өвөрхангай аймгийн Хужирт сум Нагано мужийн Маруко хоттой, Баянхонгор аймаг Ойта мужтай, Налайх дүүрэг Хоккайдо мужийн Ниикаппү хоттой, Улаанбаатар хот Миязаки мужийн Мияконожёо хот, Хоккайдо мужийн Саппоро хотуудтай харилцаа тогтоож, шууд хамтран ажиллаж байна. 2008 оноос Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг Нагано мужийн Сакү хоттой, Өвөрхангай аймгийн Хархорин хот Канагава мужийн Камакүра хоттой тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. 2011 оны 7 дугаар сард Дорноговь аймаг Шизүока мужтай, 2012 онд Өвөрхангай аймаг Гүнма мужтай, 2014 онд Хөвсгөл аймаг, Нийгата мужтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд Ховд аймаг Вакаяма мужтай, Дорнод аймаг Фүкүока мужтай, Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэг Шизүока мужийн Изүнокүни хоттой орон нутгийн шууд хамтын ажиллагаа хөгжүүлэх эхлэл тавигдаад байна.<sup>34</sup>

Япон улсад харьцангуй олон их дээд сургуульд монгол хэл зааж, монгол судлалыг амжилттай хөгжүүлж байгаа бөгөөд үүнд Осоакагийн их сургууль, Токиогийн гадаад судлалын их сургууль, Тоохокү их сургууль, Васеда их сургууль, Оотани их сургууль зэргийг дурдаж болно.<sup>35</sup>

Монгол, Япон Улс 1991 оноос эхлэн соёлын өдрүүд, кино үзлэг тогтмол зохион байгуулж, үзэсгэлэн гаргаж, урлагийн хэсгүүд харилцан айлчлан тоглолт хийх болсон. Монгол, Японы Соёлын анхдугаар форумыг 1999 онд Токио хотод, улмаар ээлжит форумуудыг 2000, 2007, 2010 онд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан.<sup>36</sup> Япон улсын иргэн, дуучин Яширо Аки, зураач Шингэцү Шикандай, Монгол Улсын Өргөмжит консул асан Сато Норико нар 2016 оноос Монгол Улсын Соёлын элчээр томилогдон

---

<sup>33</sup>Монгол улсаас Япон улсад суугаа ЭСЯ <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>

<sup>34</sup>Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>

<sup>35</sup>Монгол судлалын мэдээллийн нэгдсэн сан (2015.11.15)

<http://www.mongolstudies.gov.mn/index.php/en/mongolia/asia/2015-11-15-06-50-52/2015-11-15-06-58-06>

<sup>36</sup>Мөн тэнд.

ажиллаж байна.<sup>37</sup> Мөн сүүлийн үед японы гоо даам, “соробан” сампин, роботын чиглэлээр сонирхон суралцаж буй монголын хүүхэд залуусын тоо ихсэх хандлагатай байна.

Япон улсын засгийн газрын Соёлын Ерөнхий буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол Улсад 2014 оны санхүүгийн жил хүртэл нийт 24 төсөлд 1 тэрбум 556 сая 300 мянган иений хамтын ажиллагаа хэрэгжээд байна.<sup>38</sup> Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж нь хөгжиж буй орнуудын соёл, дээд боловсролыг хөгжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга байгууламжийг сайжруулах (шинээр барих, засварлах) зэрэгт шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангадаг тусламж юм.

“Соёлын өвсний үндэс” буцалтгүй тусламж нь орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага зэрэг хөгжиж буй орны ард иргэдийн түвшинд шууд тусламж үзүүлэхийг зорьдог хөтөлбөр бөгөөд 2015 он хүртэл Монгол Улсад нийт 412,580 ам.долларын өртөг бүхий 6 төсөл хэрэгжүүлээд байна.<sup>39</sup>

Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв нь 2002 оноос эхлэн Монгол, Япон хоёр орны харилцааг бэхжүүлэх, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэхэд туслах, зорилготойгоор үйл ажиллагаа явуулсаар ирсэн бөгөөд 2009 оны 7 дугаар сард тус төвөөр үйлчлүүлэгчдийн тоо 1 саяд, 2016 оны 4 дүгээр сард 2 саяд хүрчээ.<sup>40</sup>

Япон улсад 2021 оны байдлаар 13,500 монгол иргэн оршин сууж байсан ба 1996 онд байгуулагдсан “Япон дахь Монгол оюутны холбоо”, 2016 онд байгуулагдсан “Япон дахь монгол иргэдийн нэгдсэн холбоо” гэсэн монгол иргэдийн хоёр холбоо тус улсад үйл ажиллагаа явуулж байна.<sup>41</sup>

Монгол Улсад жуучлах япон иргэдийн тоо 2011 оноос тогтмол өсч, 2019 онд 24,419-д хүрч байсан боловч цар тахлын улмаас япон жуулчдын тоо огцом буураад байна (Зураг 1-

---

<sup>37</sup>ГХЯ, Монгол, Японы харилцааны товч лавлах. [http://www.mfa.gov.mn/?page\\_id=14886#1489665313491-046e3cfb-6626](http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626)

<sup>38</sup>Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, “Соёлын Ерөнхий БуцалтгүйТусламж” <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/bunkamusyou.htm>


<sup>39</sup>Мөн тэнд

<sup>40</sup>Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв, <http://www.japan-center.mn/home.shtml;jsessionid=C400ED1CA382D0979038D8846C0351C8>

<sup>41</sup>ГХЯ, “Монгол, Японы харилцааны товч лавлах” [http://www.mfa.gov.mn/?page\\_id=14886#1489665313491-046e3cfb-6626](http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626)

ийг үзнэ үү). Япон улс Монгол Улсад ирсэн нийт жуулчдын тоогоор 4 дүгээр байр эзэлж байв.<sup>42</sup>

*Зураг 1. Монгол Улсад жуулчилсан япон иргэдийн тоо (2011-2021 он)*



Эх сурвалж: ҮСХ

### Дүгнэлт

Япон улсын “стратегийн түншлэл”-ийн харилцааны нэг онцлог нь АНУ-ын холбоотон/түншүүдтэй ийм төрлийн харилцаа тогтоохыг эрмэлздэгт оршино. Ингэснээр дээр дурдсанчлан, түншүүдээ төрөлжүүлэх, олон улстай ердийн харилцаанаас илүү өргөн хүрээнд харилцах боломжтой болдог.

Тус улсын бусад улстай тогтоосон “стратегийн түншлэл”-ийн харилцааны нийтлэг шинж нь эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэхэд төвлөрсөн байдаг. Тийм учраас Япон стратегийн түншлэл байгуулсан улсуудтайгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг гол төлөв байгуулж байна.

Монгол Улс, “туравдагч хөрш”-ийн орнуудын тогтоосон улс төрийн харилцааг хоёр хөршийнхтэй харьцуулбал тэнцвэртэй байгаа нь сайшаалтай боловч цаашид ч ардчилал,

<sup>42</sup>БОАЖЯ, 2016 оны жилийн эцсийн мэдээг 2015 оны мөн үетэй харьцуулсан мэдээ <http://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2017/01/2016-onii-jiliin-etses.pdf>

хүний эрхийн үнэт зүйлд тулгуурлан эдгээр оронтой улс төрийн харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Ингэхдээ ардчиллыг хөгжүүлэхэд Монгол Улсын хуримтлуулсан туршлага, мэдлэгийг ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улсуудад түгээн дэлгэрүүлэхэд “гуравдагч хөрш”-ийн орнуудын дэмжлэгийг авах замаар хамтран ажиллах боломжтой. Энэ нь Монгол болон “гуравдагч хөрш”-ийн орнуудын харилцааг шинэ шатанд гаргахад тустай болно.

Стратегийн түншлэлийг эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх улс төрийн арга хэрэгсэл хэмээн өрнөдийн судлаачид дүгнэснээс үзэхэд, Монгол болон “гуравдагч хөрш”-ийн орнуудтай тогтоосон стратегийн түншлэлд эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэх зорилго агуулагдаж байна. 1990-ээд оноос “гуравдагч хөрш”-ийн орнуудтай идэвхтэй харилцаж байгаа байдлыг хоёр хөрш, тэр дундаа БНХАУ-тай харилцаж буйтай харьцуулахад эдийн засгийн харилцаа нэн сул байгаа нь харагдлаа. Үүнд газар нутгийн хол байдал нөлөөлж, “гуравдагч хөрш”-ийн орнуудтай худалдааны өргөн харилцаа тогтоох боломжийг хязгаарлаж байна.

Харин “гуравдагч хөрш”-ийн орнуудтай хөгжүүлж буй стратегийн түншлэлийн харилцаа зээл, тусламжийн чиглэлд хамгийн их үр, өгөөжөө өгч, манай улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна. ЗХУ болон Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл задарснаар Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн хүнд хэцүү жилүүдэд Япон зэрэг “гуравдагч хөрш”-ийн донор орон, банк, санхүүгийн байгууллагууд Монгол Улсад дэмжлэг үзүүлж, олон төрлийн зээл, тусламж олгосон байна. Үүнд юун түрүүнд Японы оруулж буй хувь нэмрийг онцгойлон дурдах шаардлагатай. Монгол Улсад үзүүлсэн зээл, тусламжийн хэмжээгээрээ Япон нь манай улсын хамгийн том санхүүгийн түнш юм.

Боловсролын салбарт, тэр дундаа монгол оюутныг засгийн газрын болон бусад шугамаар суралцуулах үйлст Японы оруулж буй хувь нэмэр өндөр байна. Үүнд, Япон улсад 1005 инженерийг бэлтгэх зорилготой “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг онцлон дурдах хэрэгтэй.

Гадаадад нийт оршин суугаа иргэдийн олонхи нь “гуравдагч хөрш”-ийн орнууд, түүний дотор БНСУ, АНУ, Япон зэрэг улсад ажиллаж, амьдарч байна. Энэ нь хоёр хөрштэй харьцуулахад “гуравдагч хөрш”-ийн орнуудтай иргэд хоорондын харилцаа харьцангуй сайн байгааг харуулж байгаа юм. Манай залуучуудын дунд хийсэн олон нийтийн санал асуулгаас

цаашид ч энэ тоо өсөх хандлагатай байна. Мөн “гуравдагч хөршийн орнуудаас манай улсад жуулчлах болон манайхаас тэдгээр улсад аялах явдал ихээхэн нэмэгдэж байна.

## НОМ ЗҮЙ:

### *Монгол хэлээр:*

1. БОАЖЯ, 2016 оны жилийн эцсийн мэдээг 2015 оны мөн үетэй харьцуулсан мэдээ <http://tourism.ub.gov.mn/wp-content/uploads/2017/01/2016-onii-jiliin-etses.pdf>
2. Гадаад харилцааны яам, “Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Япон улсад айлчилна” (2018.12.10) <https://mfa.gov.mn/49231>
3. Гадаад харилцааны яам, “Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн тухай” (2022.05.01) <https://mfa.gov.mn/67879>
4. Гадаад харилцааны яам, “Монгол, Японы харилцааны товч лавлах” [http://www.mfa.gov.mn/?page\\_id=14886#1489665313491-046e3cfb-6626](http://www.mfa.gov.mn/?page_id=14886#1489665313491-046e3cfb-6626)
5. Гадаад харилцааны яам, “Монголын докторууд Токиод чууллаа” (2017.05.08) <http://www.mfa.gov.mn/?p=40560>
6. Дэслэгч Д.Мөнхзориг, Соёмбо сонин “Япон улсын туршлагыг монголын хөрснөө ...” (2017.08.27) <http://www.mod.gov.mn/index.php?com=news&id=1489>
7. ЕТГ “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Япон улсад айлчилж байна” (2022.11.29) <https://president.mn/25434/>
8. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар сарын 30, Төрийн мэдээлэл, 9/1994, 781 дүгээр тал
9. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 1994 оны 6 дугаар сарын 30, Төрийн мэдээлэл, 9/1994, 805-806 дугаар тал
10. Монгол Улсын Батлан хамгаалах яам “Монгол, Японы Засгийн газар хооронд энхийг сахиулах ажиллагаанд хамтран ажиллах гэрээ байгууллаа” (2015.06.0) <http://mod.gov.mn/index.php?com=news&id=700>
11. МУИС “Японд 1000 инженер бэлдэнэ” (2016-01-29) <http://news.num.edu.mn/?p=31949>
12. Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>
13. Монгол Улсаас Японы улсын Осака хот дахь Консулын газар “Монгол, Японы батлан хамгаалах салбарын харилцаа” <https://osaka.consul.mn/index1.php?moduls=13>
14. Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв, <http://www.japan-center.mn/home.shtml;jsessionid=C400ED1CA382D0979038D8846C0351C8>
15. Монцамэ “Монгол, Япон: Стратегийн түншлэлээс Тусгай стратегийн түншлэл рүү” (2022.12.02) <https://montsame.mn/mn/read/309172>
16. Япон улсаас Монгол улсад суугаа ЭСЯ, “Соёлын Ерөнхий Буцалтгүй Тусламж” <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/bunkamuyou.htm>
17. Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам “Монгол, Японы улс төрийн харилцааны тойм” <https://tokyo.embassy.mn/index1.php?moduls=12>
18. Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=17>

19. Монгол судлалын мэдээллийн нэгдсэн сан (2015.11.15)  
<http://www.mongolstudies.gov.mn/index.php/en/mongolia/asia/2015-11-15-06-50-52/2015-11-15-06-58-06>
20. Оюунцэцэг, П, “Эрүүл мэндийн салбар дахь Монгол-Японы хамтын ажиллагаа”, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл №3, 2022: 52-53 тал
21. Өнөөдөр сонин “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Японд айлчилна” (2020.07.21)  
<https://unuudur.mn/?p=181237>
22. Сэржав,Б, “Монгол, Японы дипломат харилцаа: гүнзгийрэл, чиг хандлага” Олон улс судлал №1 (107), 2017 он: 5-23 тал
23. Уламбаяр,Д, “Монгол Улсын түншлэлийн бодлого”
24. Япон улсын ЭСЯ, Гадаад оюутны солилцоо <http://www.mn.emb-japan.go.jp/mn/culture/ryuugaku.htm>
25. VIP76 “Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ Японы Батлан хамгаалах яамны бодлогын газрын захирал Омасу Изаваг хүлээн авч уулзлаа” (2017 оны 8 дугаар сарын 29) <http://vip76.mn/content/47939>

*Англи хэлээр:*

1. Andrew L. Oros, (2008) Normalizing Japan: Politics, Identity, and the Evolution of Security Practice. Stanford, CA: Stanford University Press
2. Christopher W. Hughes (2004) “Japan’s Security Agenda: Military, Economic & Environmental Dimensions” Boulder, CO: Lynne Rienner
3. Lakhvinder Singh, “India-Japan strategic partnership must include Korea: Indian strategic thinkers who are putting all their eggs in the Japanese basket and ignoring South Korea are making a strategic blunder” (Jan 9, 2020) <https://asiatimes.com/2020/01/india-japan-strategic-partnership-must-include-korea/>
4. Nobuo Okawara, Peter J. Katzenstein (2008) “Japan and Asian-Pacific security: regionalization, entrenched bilateralism, and incipient multilateralism”, in P. Katzenstein (ed.), Rethinking Japanese Security: Internal and External Dimensions, pp. 104–132. Abingdon: Routledge
5. Richard J. Samuels, (2007) Securing Japan: Tokyo’s Grand Strategy and the Future of East Asia. Ithaca, NY: Cornell University Press
6. Takashi Terada, (2010) “Evolution of the Australian–Japan Security Partnership: Toward a Softer Triangle Alliance with the United States?”, Japan Program, IFRI Center for Asian Studies [https://www.ifri.org/sites/default/files/atoms/files/av35\\_terada\\_japan-australia-us\\_alliance\\_2010.pdf](https://www.ifri.org/sites/default/files/atoms/files/av35_terada_japan-australia-us_alliance_2010.pdf)
7. Thomas S. Wilkins, “Japan’s alliance diversification: a comparative analysis of the Indian and Australian strategic partnerships” International Relations of the Asia-Pacific Volume 11 (2011) 115–155
8. Vidaya Nadkarni, (2010) Strategic Partnerships in Asia: Balancing without Alliances. Abingdon: Routledge